


Манай орны 8 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 12°C (53.6°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +18.1°C (64.6°F) –аас +26°C (77°F), бусад нутгаар 12.1°C –аас +18°C (53.8°F –аас 64.4°F) дулаан байдаг байна.


Монгол орны хэмжээнд 8 дугаар сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 24 хувь нь ордог. Тус сард төвийн болон нутгийн хойд хэсгээр 60.1-125 мм, говь-цөлийн бүс нутгаар 5-30 мм бусад нутгаар 30.1-60 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 8 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2025 оны 8 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс -1.6°C-аар хүйтэн, ОЖД-аас 0.3°C-аар дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 15 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн дийлэнх буюу 81.4% нь дунджийн орчим, 17.8% нь дунджаас 1.1–ээс 3.0°C-аар дулаан, 0.8% нь дунджаас хүйтэн байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 44.3 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 33.4%, ОЖД-аас 3.01%-иар тус тус бага бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 38 дахь бага тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 55.8% нь дунджаас бага, 31% нь дунджаас ахиу, 13.2% -д дунджийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2025 оны 8 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 8 дугаар сарын агаарын дундаж температурын хоногийн явцыг авч үзэхэд (Зураг 3) ихэнх хугацаанд нийт нутгаар ОЖД-аас 0.2°C -аас 4.5°C -аар дулаан, харин 2 болон 3 дугаар 10 хоногийн эхэн үеэр ОЖД-аас -0.2°C -аас -4.1°C -аар хүйтэн байсан байна. Хур тунадасны хувьд 1 дүгээр 10 хоногт зүүн болон төвийн бүс нутгаар, 2 дугаар 10 хоногт зүүн, 3 дугаар 10 хоногийн эхээр ихэнх нутгаар харьцангуй ахиу хур тунадас тус тус орсон. Баруун болон өмнө бүс нутгийн хувьд харьцангуй бага хур тунадастай байжээ.




Зураг3. Хоногийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Агаарын үнэмлэхүй их температур 30°C -ыг давж халсан өдөр Баянхонгорын Эхийнгол 25 өдөр, Говь-Алтайн Тоорой, Өмнөговийн Ханбогд, Булган (Сайхан өртөө), Дорноговийн Хөвсгөл сум орчмоор 16-20 өдөр, бусад нутгаар 10-оос цөөн өдөр ажиглагджээ.



Зураг 4. 30°C -аас халуун өдрийн өдрийн тооны газарзүйн тархалт

Энэ сард агаарын температурын үнэмлэхүй их утга Өмнөговь аймгийн Ханбогд суманд 37.1°C, үнэмлэхүй бага утга Завханы аймгийн Цэцэн-Уул суманд -4.3°C хүрсэн. Харин хөрсний температурын үнэмлэхүй их утга Баянхонгор аймгийн Шинэжинст суманд (Эхийнголд) 66°C, үнэмлэхүй бага утга Завханы аймгийн Цэцэн-Уул суманд -7°C хүрч хүйтэрсэн байна. Тухайн сард хоногт хамгийн ихдээ Дорнод аймгийн Дашбалбар суманд 12-ны өдөр 69.6 мм тунадас орсон. Агаарын даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 943.2гПа, хамгийн бага утга Баянхонгорын Баянбулагт 768.2гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хамгийн их хурд Булган аймгийн Гурванбулаг суманд 37м/с хүрсэн байна.



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд